

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/31/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="#">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: <a href="#">dolqorsurenb@audit.gov.mn</a> Ахлах аудитор О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: <a href="#">bayarmaao@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Л.ЭНХБИЛЭГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1141  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний 13 байгууллагын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад байгууллага, иргэдээс байршуулсан 3,021.3 сая төгрөгийн барьцааны өр төлбөрийг санхүүгийн тайлан, данс бүртгэлд тайлагнаагүй, зөвхөн тодруулгад тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр" гэж заасантай нийцэхгүй, аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосныг үндэслэн төрийн

үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 207 дугаар тогтоолоор “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ыг баталж, мөрдсөнөөс ажлын зохист ачааллаас хэтэрсэн хувь хэмжээгээр нэмэгдэл урамшуулал олгосонтой холбоотой цалингийн зардал өмнөх оноос 16,798.1 сая төгрөгөөр буюу 33.1 хувиар өссөн байна.

Тайлант онд урсгал зардлаас шүүх хуралдааны танхимд дуу, дүрс бичлэг хийж, архивлах 44 ширхэг тоног төхөөрөмжийг 1,378.8 сая төгрөгөөр, нийслэл дэх анхан болон давж заалдах шатны 176 шүүгчийн зөөврийн компьютерыг 538.0 сая төгрөгөөр, 116 шүүхэд шаардлагатай принтер, сканерыг 200.0 сая төгрөгөөр, тавилга, эд хогшлыг 184.5 сая төгрөгөөр, нийт 2,301.3 сая төгрөгийн хөрөнгийг олж бэлтгэн хуваарилж, 767.0 сая төгрөгөөр 6 шүүхийн Тамгын газрын барилгын өрөө болон дотор халаалтын системийг засварласан байна.

### **Аудитын гол асуудал**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 09 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байрны барилга угсралтын ажилд 2013-2014 онд олгосон 4,964.4 сая төгрөгийн санхүүжилтээр зоорины В2 давхрын угсралтын ажлыг гүйцэтгэж, дуусаагүй орхигдсон барилга”-ыг Хууль зүйн яам /тухайн үеийн нэршлээр/-аас балансаас баланст шилжүүлэн авсан байна. Өмнөх онд 41.5 сая төгрөгөөр гадна инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлж, 2.6 сая төгрөгийн зардлыг аудитаас өгсөн албан шаардлагын дагуу бүртгэж, дуусаагүй барилга, байгууламжийн данс нийт 5,008.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 178 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 91.3 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн боловч дараах 3 хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл зорилтот түвшинд хүрээгүй байна. Тухайлбал:

1. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах, цахим нотлох баримтыг үнэлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах;
3. Шүүн таслах ажиллагааны онцлог, шүүгчийн хараат бус аюулгүй байдлыг хангасан байхаар шүүхийн захиргааны зарим үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлэх нөхцөл, дүрэм, журмыг боловсруулж, батлуулах.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,019,887.1	2,927,241.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,381,185.2	378,860.0
33	АВЛАГА	306,707.8	44,910.2
34	УРЬДЧИЛГАА	472,867.2	712,021.2
35	БАРАА МАТЕРИАЛ	1,716,061.5	1,791,450.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	143,065.4	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,653,332.9	54,496,962.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,653,332.9	54,496,962.3
39200	Биет хөрөнгө	48,951,607.5	49,586,318.9
39300	Биет бус хөрөнгө	4,701,725.4	4,910,643.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	57,673,220.0	57,424,203.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	108,939.8	56,743.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	108,939.8	56,743.6
41300	Өглөг	108,939.8	56,743.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	57,564,280.2	57,367,460.2
51	Засгийн газрын хувь оролцоо	57,564,280.2	57,367,460.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	21,768,223.2	21,777,423.2
51200	Хуримтлагдсан үр дүн	22,726,910.9	22,525,249.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,069,146.1	13,064,787.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	57,673,220.0	57,424,203.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	80,761,166.9	93,664,605.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,463,852.1	1,213,825.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,084,154.9	1,213,825.6
122	Тусламжийн орлого	379,697.2	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,297,314.8	92,450,780.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	78,289,314.5	93,859,516.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,289,314.5	93,859,516.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,751,241.9	91,186,623.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,634,694.0	67,300,480.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,401,396.1	8,408,163.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,063,168.2	2,424,625.4
2104	Хангамж, бараа материалын зардал	3,805,920.7	4,176,270.0
2105	Нормативт зардал	14,162.3	7,117.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,221,318.8	2,056,349.1
2107	Томилолт, зочны зардал	263,248.3	601,589.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,003,785.4	1,635,052.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,343,548.1	4,576,975.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,538,072.6	2,672,893.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,471,852.4	(194,910.5)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	72,330.5	11,109.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,399,521.9	(206,020.1)

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	81,270,661.7	93,449,531.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,682,099.7	726,114.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,682,099.7	726,114.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,588,562.0	92,723,417.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,490,728.0	92,240,810.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,490,728.0	92,240,810.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,652,815.7	89,547,528.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,733,132.3	67,571,053.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,390,932.6	8,382,175.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,060,537.6	2,426,887.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,586,741.8	3,889,961.9
2105	Нормативт зардал	27,275.0	23,981.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,420,718.0	4,017,779.1
2107	Томилолт, зочны зардал	266,090.1	611,548.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,593,965.2	1,899,117.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	573,423.1	725,023.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,837,912.3	2,693,282.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,779,933.7	1,208,721.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,398,748.5	2,211,046.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,398,748.5	2,211,046.4
2200	Дотоод эх үүсвэрээр	4,398,748.5	2,211,046.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,398,748.5)	(2,211,046.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,381,185.2	(1,002,325.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,381,185.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,381,185.2	378,860.0

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	55,165,518.4	-	55,165,518.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	18,594.1	-	18,594.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,184,112.5	-	55,184,112.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(19,354.2)	-	(19,354.2)
Тайлант үеийн үр дүн	2,399,521.9	-	2,399,521.9
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,564,280.2	-	57,564,280.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,358.4	-	4,358.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,568,638.6	-	57,568,638.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4,358.4)	-	(4,358.4)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	9,200.0	-	9,200.0
Тайлант үеийн үр дүн	(206,020.1)	-	(206,020.1)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,367,460.2	-	57,367,460.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	94,448,817,700.00	91,243,392,513.13	3,205,425,186.87	96.6
УРСГАЛ ЗАРДАЛ	94,448,817,700.00	91,243,392,513.13	3,205,425,186.87	96.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,701,343,400.00	89,885,725,259.98	815,618,140.02	99.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,803,517,700.00	67,527,156,390.50	276,361,309.50	99.6
Үндсэн цалин	43,590,581,700.00	42,700,579,929.08	890,001,770.92	98.0
Нэмэгдэл	15,956,558,100.00	14,591,690,696.73	1,364,867,403.27	91.4
Унаа хоолны хөнгөлөлт	3,065,468,000.00	3,228,810,146.04	(163,342,146.04)	105.3
Урамшуулал	5,190,909,900.00	7,006,075,618.65	(1,815,165,718.65)	135.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	8,495,054,000.00	8,376,860,452.52	118,193,547.48	98.6
Тэтгэврийн даатгал	6,108,648,500.00	5,827,325,446.40	281,323,053.60	95.4
Тэтгэмжийн даатгал	596,632,600.00	645,870,951.17	(49,238,351.17)	108.3
ҮОМШӨ-ний даатгал	475,406,000.00	510,857,657.35	(35,451,657.35)	107.5
Ажилгүйдлийн даатгал	123,851,800.00	127,805,878.05	(3,954,078.05)	103.2
Эрүүл мэндийн даатгал	1,190,515,100.00	1,265,000,519.55	(74,485,419.55)	106.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,514,805,200.00	2,426,887,026.35	87,918,173.65	96.5
Гэрэл, цахилгаан	584,168,000.00	549,701,075.09	34,466,924.91	94.1
Түлш, халаалт	1,215,647,900.00	1,180,712,117.71	34,935,782.29	97.1
Цэвэр, бохир ус	185,564,300.00	175,777,000.71	9,787,299.29	94.7
Байрны түрээс	529,425,000.00	520,696,832.84	8,728,167.16	98.4
Хангамж, бараа материалын зардал	3,890,783,400.00	3,830,644,053.38	60,139,346.62	98.5
Бичиг хэрэг	1,615,051,900.00	1,640,420,029.00	(25,368,129.00)	101.6
Тээвэр, шатахуун	819,000,100.00	821,895,085.00	(2,894,985.00)	100.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	736,278,300.00	683,238,919.78	53,039,380.22	92.8
Ном, хэвлэл	79,656,600.00	57,278,380.00	22,378,220.00	71.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,243,500.00	29,339,900.00	9,903,600.00	74.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	601,553,000.00	598,471,739.60	3,081,260.40	99.5
Нормативт зардал	29,948,100.00	23,981,625.00	5,966,475.00	80.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,948,100.00	23,981,625.00	5,966,475.00	80.1
Эд хогшил, урсгал засварын зардал	4,790,884,700.00	4,725,130,703.04	65,753,996.96	98.6
Багаж, техник, хэрэгсэл	2,460,977,600.00	2,406,921,889.04	54,055,710.96	97.8
Тавилга	373,800,000.00	373,287,350.00	512,650.00	99.9
Урсгал засвар	1,956,107,100.00	1,944,921,464.00	11,185,636.00	99.4
Томилолт, зочны зардал	560,004,800.00	523,205,152.91	36,799,647.09	93.4
Дотоод албан томилолт	560,004,800.00	523,205,152.91	36,799,647.09	93.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,981,094,700.00	1,846,159,575.26	134,935,124.74	93.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,022,728,300.00	907,166,524.46	115,561,775.54	88.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,040,900.00	3,489,200.00	2,551,700.00	57.8
Даатгалын үйлчилгээ	771,894,800.00	769,505,768.00	2,389,032.00	99.7
Тээврийн хэрэгслийн татвар	13,568,700.00	9,841,243.80	3,727,456.20	72.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	4,634,700.00	3,177,000.00	1,457,700.00	68.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,566,800.00	127,707,796.00	4,859,004.00	96.3
Газрын төлбөр	29,660,500.00	25,272,043.00	4,388,457.00	85.2
Бараа үйлчилгээний бусад зардал	635,250,800.00	605,700,281.02	29,550,518.98	95.3
Бараа үйлчилгээний бусад зардал	606,150,800.00	576,951,567.02	29,199,232.98	95.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,100,000.00	28,748,714.00	351,286.00	98.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,747,474,300.00	1,357,667,253.15	2,389,807,046.85	36.2
Бусад урсгал шилжүүлэг	3,747,474,300.00	1,357,667,253.15	2,389,807,046.85	36.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,718,500.00	5,718,428.00	72.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,637,269,500.00	1,267,227,569.15	2,370,041,930.85	34.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	104,486,300.00	84,721,256.00	19,765,044.00	81.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	94,448,817,700.00	91,243,392,513.13	3,205,425,186.87	96.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	94,178,817,700.00	90,910,969,063.03	3,267,848,636.97	96.5
Улсын төсвөөс санхүүжих	94,178,817,700.00	90,910,969,063.03	3,267,848,636.97	96.5

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	270,000,000.00	332,423,450.10	(62,423,450.10)	123.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000,000.00	332,423,450.10	(62,423,450.10)	123.1
БАЙГУУЛЛАГЫН ТОО	156	156	-	100.0
Төсвийн байгууллага	156	156	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	2160	2000	160	92.6
Удирдах ажилтан	176	166	10	94.3
Гүйцэтгэх ажилтан	1762	1765	(3)	100.2
Үйлчлэх ажилтан	222	69	153	31.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ОРЛОГЫН ДҮН		1,005,682,287.76
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		295,839,792.00
ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		460,465,871.76
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		82,500,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		166,876,624.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,005,682,287.76
А. УРСГАЛ ЗАРДАЛ		997,400,387.76
1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		731,477,284.75
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		43,224,715.00
Үндсэн цалин		14,299,521.00
Нэмэгдэл		28,925,194.00
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,315,367.75
Тэтгэврийн даатгал		3,849,037.62
Тэтгэмжийн даатгал		366,582.66
ҮОМШӨ-ний даатгал		293,266.22
Ажилгүйдлийн даатгал		73,316.44
Эрүүл мэндийн даатгал		733,164.81
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		682,937,202.00
Хангамж, бараа материалын зардал		61,866,560.00
Эд хогшил, урсгал засварын зардал		286,813,250.00
Томилолт, зочны зардал		87,907,340.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		116,111,260.00
Бараа үйлчилгээний бусад зардал		130,238,792.00
2. УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		265,923,103.01
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		234,699,782.00
Олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		31,223,321.01
3. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		8,281,900.00
Дотоод эх үүсвэрээр		8,281,900.00
Бусад хөрөнгө		8,281,900.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 387.3 сая төгрөгийн 26 алдааг илрүүлж, аудитын явцад залруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 269.4 сая төгрөгийн 53 зөрчил илэрснээс, 33.8 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 65.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 албан шаардлага, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 170.6 сая төгрөгийн 33 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 42 байгууллага, төвлөрсөн төсвийн 1 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 12 байгууллагыг түүврийн аудитад хамруулж, 31 байгууллагад аудит хийж, дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан 31 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3,389.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх 3,371.4 сая төгрөгийн 3 албан шаардлага, 18.0 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 3,658.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,714.2 сая төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

##### 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад байгууллага, иргэдээс байршуулсан барьцаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэр бүхий 13 Тамгын газрын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад байгууллага, иргэдээс байршуулсан 3,021.3 сая төгрөгийн барьцааны өр төлбөрийг санхүүгийн тайлан, данс бүртгэлд тайлагнаагүй, зөвхөн тодруулгад тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад байгууллага, иргэдээс байршуулсан барьцааны өр төлбөрийг санхүүгийн тайлан, данс бүртгэлд тайлагнаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

##### 2. Ахмадын санд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны төсөвт тусгаагүй, нийт 319.8 сая төгрөгийн зардлын хэмнэлтийг Ахмадын санд төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3-т "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны төсөвт тусгаагүй, зардлын хэмнэлтийг Ахмадын санд төвлөрүүлсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

##### 3. Засварын ажлын чанарын баталгаат хугацааны барьцаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд гүйцэтгэсэн Төв, Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын, Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын барилгын дотор халаалтын системийг

шинэчлэн засварлах ажлын чанарын баталгаат хугацааны барьцааны 13.3 сая төгрөгийг байршуулаагүй,

**Илрүүлэлт:** Өмнөх оноос шилжих Баянгол, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын гадна хана дулаалж, фасад хийх засварын ажлын чанарын баталгаат хугацааны барьцааны 17.0 сая төгрөгийг олгосон санхүүжилтээс суутган тооцсон боловч барьцааны дансанд шилжүүлэн байршуулаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8-д "Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.6-д заасны дагуу зохицуулна.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно", 42.6-д "Гүйцэтгэгч энэ хуулийн 42.5-д заасан барьцааг энэ хуулийн 42.3-т заасан хэлбэрээр гаргаж болно", Шүүхийн ерөнхий зөвлөлийн "Шүүхийн газруудын барилгын гадна хана дулаалж, фасад хийх, барилгын дотор халаалтын системийг шинэчлэн засварлах ажил"-ыг гүйцэтгүүлэх нэр бүхий 4 аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 2022 оны 171, 2023 оны 73, 80, 92 дугаар гэрээний Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 5.2-т "Чанарын баталгаа шаардана, чанарын баталгааны хэмжээ гэрээний үнийн дүнгийн 5.0 хувь байна", ГЕН 5.6-д " Баталгаат хугацаа шаардана. Баталгаат хугацаа Барилгын тухай хуульд заасны дагуу нэг жил байна" гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Барилгын дотор халаалтын системийг шинэчлэн засварлах болон гадна хана дулаалж, фасад хийх засварын ажлын чанарын баталгаат хугацааны барьцаа байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд зохион байгуулсан "Нийт шүүгчийн чуулган"-д шаардагдах зардлын төсвийг зохион байгуулах ажлын хэсгийн тогтоолоор баталж, гүйцэтгэлээр хоолны зардлын баталсан төсвийг 18.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Говь-Алтай аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	0.6			1	0.6	1	0.6				
2	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	7.4			1	7.4	1	7.4				
3	Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газар	2	2.2			2	2.2	2	2.2				
4	Дорнод аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	4.1			1	4.1	1	4.1				
5	Өвөрхангай аймаг дахь шүүхийн Тамгын газар	2	9.9			2	9.9	2	9.9				
6	Өмнөговь аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	13.6			1	13.6	1	13.6				
7	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	2	0.2			2	0.2	2	0.2				
8	Төв аймаг дахь шүүхийн Тамгын газар	6	214.2			6	214.2	6	214.2				
9	Хөвсгөл аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	0.5			1	0.5	1	0.5				
10	Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	7.5			1	7.5	1	7.5				
11	Нийслэлийн Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	0.0			1	0.0	1	0.0				
12	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ЭХАШШ-ийн Тамгын газар	1	39.6			1	39.6	1	39.6				
13	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШШ-ийн Тамгын газар	2	2.5			2	2.5	2	2.5				
14	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	0.5			1	0.5	1	0.5				
15	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	3	84.5			3	84.5	3	84.5				
	<b>Дүн</b>	26	387.3			26	387.3	26	387.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	1.5			1	1.5						
2	Говь-Алтай аймаг дахь шүүхийн Тамгын газар	2	2.9			2	2.9						
3	Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-ийн Тамгын газар	3	10.2	1	1.1			2	9.1				
4	Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	3	17.0					3	17.0				
5	Дорнод аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	-					1	-				
6	Дундговь аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	1.7	1	1.7								
7	Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газар	2	22.4					2	22.4				
8	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар	1	-					1	-				
9	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	1	-					1	-				
10	Өмнөговь аймаг дахь шүүхийн Тамгын газар	2	3.6			1	3.6	1	-				
11	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	2	1.1			1	1.1	1	-				
12	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн Тамгын газар	2	17.5			1	3.5	1	14.0				
13	Сэлэнгэ аймаг Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	2	6.8			1	0.8	1	6.0				
14	Сэлэнгэ аймаг Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	1	2.2					1	2.2				
15	Сүхбаатар аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	12.2			1	12.2						
16	Төв аймаг дахь шүүхийн Тамгын газар	6	30.4	2	9.4	3	21.0	1	-				
17	Хөвсгөл аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	-					1	-				
18	Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	0.9					1	0.9				
19	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ЭХАШШ-ийн Тамгын газар	2	50.0					2	50.0				
20	Нийслэлийн Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	8.3					1	8.3				
21	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШШ-ийн Тамгын газар	1	1.2					1	1.2				
22	Нийслэлийн Багахангай Налайх дүүргийн шүүхийн Тамгын газар	2	1.0					2	1.0				
23	Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	0.6					1	0.6				
24	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	2	18.0					2	18.0				
25	Багануур дүүргийн шүүхийн Тамгын газар	3	9.0			1	-	2	9.0				
26	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	8	50.9	2	21.6	1	18.4	4	10.9	1	2		
	Дүн	53	269.4	6	33.8	13	65.0	33	170.6	1	2		
27	ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан	4	3,389.4			3	3,371.4	1	18.0				
	Дүн	4	3,389.4			3	3,371.4	1	18.0				
	Нийт дүн	57	3,658.8	6	33.8	16	3,436.4	34	188.6	1	2		

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал</b>									
1	Дархан-Уул аймаг дахь ДЗШШ-ийн Тамгын газар	1	13.4					1	13.4
2	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	1	-					1	-
3	Өмнөговь аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	-					1	-
4	Сэлэнгэ аймаг Сайхан суман дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	1	-					1	-
5	Нийслэлийн Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	260.7					1	260.7
6	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШШ-ийн Тамгын газар	1	-					1	-
7	Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	-					1	-
8	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	1	162.3					1	162.3
9	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	2	-					2	-
	Дүн	10	436.4					10	436.4
<b>Бусад хууль, тогтоомжтой холбоотой асуудал</b>									
1	Нийслэлийн Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн Тамгын газар	2	-			1	-	1	-
2	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	3.8					1	3.8
3	ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан	2	-			1	-	1	-
	Дүн	5	3.8			2	-	3	3.8
	Нийт дүн	15	440.2			2	-	13	440.2